

# МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН НАСЖИЛТЫН АСУУДЛААРХ ҮНДЭСНИЙ СТРАТЕГИ



“МӨНХИЙН ҮСЭГ ГРУПП”ХХК-д хэвлэв.  
Утас: 319658, 320807, 321316  
Веб хаяг:[www.munkhiin-useg.mn](http://www.munkhiin-useg.mn)

Улаанбаатар 2009

## ӨМНӨХ ҮГ

Хорьдугаар зуунд хүн амын насжилт гол төлөв хөгжлийг орнуудад явагдаж байсан бол өнөө үед хөгжиж буй орнуудад илүү эрчимтэй явагдах боллоо. Ялангуяа, Зүүн, Зүүн өмнөд Азийн орнуудад ахмад настны тоо ойрын 30-40 жилд огцом нэмэгдэж, нийт хүн амын 20 гаруй хувийг эзлэх төлөвтэй байна. Насжилттай холбоотойгоор ахмад настны эрүүл мэнд, нийгмийн хамгааллыг сайжруулах, орлогын баталгаат байдлыг хангах, тэдэнд ээлтэй амьдрах орчинг бүрдүүлэх зэрэг шийдвэрлэх ёстой олон асуудал шинээр гарч байна. Иймээс НҮБ-аас улс орнуудыг энэ асуудлаар үндэсний бодлого, стратегиа боловсруулан хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна.

Манай улсад ойрын 20-иод жилийн хугацаанд хүн ам зүйн цонх нээгдэж байгаа тааламжтай үе үргэлжлэх боловч цааших хугацаанд насжилт явагдах хэтийн төлөв ажиглагдаж байна. Насжих үйл явц эрчимжсэнээр эрүүл мэнд, нийгмийн хамгааллын болон ахмад настанд үзүүлэх асрамж, халамжийн үйлчилгээний зардал өсөн нэмэгдэж, төсөв барагүй ачаалал үүрэх төлөвтэй байна. Иймээс энэ үйл явцад эртнээс бэлтгэх, хүн ам зүйн өнөөгийн тааламжтай бүтцийг насжилтын утвар нөхцөл болгон ашиглаж, нөхөн үржихүйн насны хүн амын зохицтой төрөлтийг дэмжих, насны бүтцийн тааламжтай өөрчлөлтийг эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлоготой уялдуулан зохицуулах, тооны хувьд байнга өсөн нэмэгдэх ахмад настны аж байдлыг сайжруулах зэрэг асуудлуудыг харилцан уялдаатайгаар авч үзэх шаардлага зүй ёсоор гарч байна.

Энэхүү стратеги нь хүн амыг насжилтын үйл явцад бэлтгэх, ахмад настны аж байдлыг сайжруулах талаар 2030 он хүртэл баримтлах урт хугацааны бодлогын чиглэл, ойрын болон дунд хугацаанд явуулах үйл ажиллагаа, авах арга хэмжээний үндэслэл бөгөөд бусад салбарын бодлого, арга хэмжээний удирдамж юм. Хүн амын насны бүтцэд гарч буй өөрчлөлт хандлагад суурисан төлөвлөлтийн зарчмыг бүхий л салбарт нэвтрүүлэх, стратегид туссан асуудлыг жил бүрийн нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, холбогдох яамд, байгууллагуудын үйл ажиллагаатай тусган уялдуулах замаар хэрэгжүүлэх болно.

Стратегийг боловсруулахад хамтран ажилласан бүх байгууллага, хүмүүст талархал илэрхийлэхийн ялдамд энэхүү стратеги Та бүхний өдөр тутмын хэрэгцээт ширээний ном байна гэдэгт итгэлтэй байна.

**Монгол Улсын Засгийн газрын гишүүн,  
Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд  
Т.ГАНДИ (PhD)**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 5 дугаар  
сарын 27-ны өдөр

Дугаар 156

Улаанбаатар  
 хот

Монгол Улсын хүн амын насжилтын асуудлаархи  
Үндэсний стратегийн тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.4.7-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын хүн амын насжилтын асуудлаарх Үндэсний стратегийг сайшаасугай.

2. Үндэсний стратегийн зорилтыг салбарын болон үндэсний хөгжлийн дунд, урт хугацааны бодлого, хууль тогтоомжид тусган хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди, Эрүүл мэндийн сайд С.Ламбаа, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо /Ч.Хашчулуун/-нд тус даалгасугай.

## ГАРЫН ҮСЭГ

Монгол Улсын Засгийн газрын  
2009 оны 5 сарын 27-ны өдрийн 156  
дугаар тогтоолын хавсралт

## МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН НАСЖИЛТЫН АСУУДЛААРХ ҮНДЭСНИЙ СТРАТЕГИ

### НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Дэлхийн улс орнуудад хүн амын насжилт идэвхжих хандлагатай байна. Энэ нь нийт хүн амд ахмад (60 ба түүнээс дээш) настны эзлэх хувийн жингийн өсөлтөөр илэрч, төрөлт, нас баралт гэсэн хүн ам зүйн хоёр хүчин зүйлээс шууд хамаардаг ба нас баралт буурснаар ахмад настны тоо өсч, төрөлт буурснаар тэдний хүн амд эзлэх хувь хэмжээ нэмэгдэх үйл явц юм.

Олон улс орон насжилтаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн асуудалтай тулгарч байна. Өнгөрсөн зуунд насжилт гол төлөв хөгжингүй орнуудын хувьд тулгамдсан асуудал болж байсан бол ирэх 50-60 жилд хөгжиж буй орнуудын хувьд анхаарал татах асуудлын нэг болох төлөвтэй байна.

Дэлхий дээр 2005 оны байдлаар 65 ба түүнээс дээш настай 476 сая гаруй хүн байгаагаас 38.9 хувь нь хөгжингүй, 60 гаруй хувь нь хөгжиж буй орнуудад амьдарч байна (НҮБ 2007). Энэ тоо 2050 он гэхэд бараг 2 тэрбумд хүрч, нийт хүн амын 20 гаруй хувийг эзлэх, тэдний гуравны нэг нь Зүүн болон Зүүн өмнөд Азийн бүсэд амьдрах төлөвтэй байна.


Нийгэм, эдийн засгийн хөгжлийн харьцангуй доогуур түвшинтэй улс орнуудад хүн амын насжилтын сөрөг үр дагавар хөгжингүй орнуудаас илүү хүнд тусах магадлалтай учраас хүн амын насжилтад эртнээс бэлтгэх, хүн ам зүйн өнөөгийн тааламжтай бутцийг насжилтын угтвар нөхцөл болгон ашиглахыг чухалчилж байна.

Манай орны хүн амын төрөлтийн түвшин 1970-аад оны дунд үеэс аажмаар, 1990-ээд оны эхэн үеэс эрчимтэй буурч, 2005 оноос төрөлтийн эргэн нөхөгдөх түвшнээс доогуур болжээ. Үүнээс шалтгаалж хүн амын насны бүтэц өөрчлөгдж байна. Тухайлбал, 1970-аад оны дунд үед хөдөлмөрийн насны 100 хүн амд ногдох хүүхэд, ахмад настны тоо буюу хүн ам зүйн ачаалал 99.7 байсан бол 1990-ээд оны үед 76.5, 2008 онд 52.0 болсон байна.

Хүн ам зүйн ачаалал буурснаар хөдөлмөрийн насны хүн ам, нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн тоо хамгийн их байх үе болох "хүн ам зүйн цонх" нээгдэж, хүн ам насны бүтэц идэршиж байна. Энэ нь хүн ам зүйн талаасаа тааламжтай үе боловч тодорхой хугацааны дараа түүний сөрөг үр дагавар хүчтэй илрэх болно. (Зураг 1).

Зураг 1.

### Хүн амын нас, хүйсийн суварга



Эх үүсвэр: Монгол Улсын хүн амын 2008-2030 оны хэтийн тооцоо

Монгол Улсад хүн амын насжих явц 20-иод жилийн дараагаас эхлэх бөгөөд дараачийн 20 жилд идэвхжих, үүнтэй холбоотойгоор эрүүл мэнд, нийгмийн хамгааллын болон ахмад настанд үзүүлэх асрамж, халамжийн үйлчилгээний зардал өсөн нэмэгдэж, төсөв багагүй ачаалал үүрэх төлөвтэй байна.

| Хүснэгт 1. Нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн үйлчилгээний хэрэгцээ, 2005 онтой 2010, 2020, 2030, 2040, 2050 оныг харьцуулсан байдлаар |                                 |       |       |        |        |   |
|---|---------------------------------|-------|-------|--------|--------|---|
|   | 2005 онтой харьцуулсан өөрчлөлт |       |       |        |        |   |
|   | 2010*                           | 2020* | 2030* | 2040** | 2050** | Тайлбар   |
| 60 ба түүнээс дээш насны хүн ам   | 1.03                            | 1.22  | 1.79  | 1.81   | 1.37   | 2005 оны үзүүлэлтээс хэд дахин нэмэгдэж байгааг харуулна.                                     |
| 65 ба түүнээс дээш насны хүн ам   | 1.05                            | 1.11  | 66.90 | 0.05   | 1.39   |   |
| 80 ба түүнээс дээш насны хүн ам   | 1.03                            | 1.22  | 1.24  | 1.34   | 1.83   |   |
| 0-14 насны хүүхэд   | 1.06                            | 1.06  | 0.98  | 0.74   | 0.97   |   |
| Насны голч  | 0.7                             | 4.8   | 8.2   | 14.6   | 16.7   | 2005 оноос хэдэн жилээр нэмэгдэж байгааг харуулна.  |
| Дундаж наслалт /нийт/   | 3.3                             | 5.9   | 8.3   | 9.3    | 11.0   |   |
| Эрэгтэй   | 4.3                             | 6.9   | 9.1   | 10.0   | 11.7   |   |
| Эмэгтэй   | 2.2                             | 5.0   | 7.4   | 8.2    | 10.0   |   |
| Хүн ам зүйн ачаалал /нийт/  | -1.1                            | -2.9  | -4.9  | -4.3   | 4.2    | 100 хөдөлмөрийн насны хүн амд ноогдох хүүхэд, ахмад настны тоо хэрхэн буурч байгааг харуулна. |
| Хүүхэд  | -0.9                            | -3.6  | -10.0 | -16.8  | -16.5  | Ахмад настан  |
| Ахмад настан  | -3.2                            | 0.7   | 5.1   | 12.5   | 20.8   |   |

Эх үүсвэр: \* Монгол Улсын хүн амын 2008-2030 оны хэтийн тооцоо

\*\* <http://data.un.org/Browse.aspx?d=PopDiv>, Хэтийн тооцооны дунд хувилбар

Иймээс хүн амын насжилтыг угтаж, нөхөн үргижүйн идэвхтэй насны хүн амын тоо өндөр байх энэ үед зохистой төрөлтийг дэмжих, насны бүтцийн тааламжтай өөрчлөлтийг эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлоготой уялдуулан зохицуулах, тооны хувьд байнга өсөн нэмэгдэх ахмад настны аж байдлыг сайжруулах зэрэг асуудлыг харилцан уялдаатайгаар авч үзэх шаардлага зүй ёсоор гарч байна.

## Стратегийн агуулга/тойм, хэрэгжүүлэх хугацаа

Хүн амын насжилт нь ирээдүйд улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд асар их нөлөө үзүүлэхүйц, бүхий л салбарыг хамарсан өргөн хүрээтэй асуудал юм. Иймд Монгол Улсын хүн амын насжилтын асуудлаарх Үндэсний стратегийн хүрээнд дараах асуудлыг шийдвэрлэх шаардлага гарч байна. Үүнд:

- Өнөөгийн хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх;
- Хөдөлмөр эрхэлж буй хүн амын нийгмийн баталгааг хангах;
- Зохистой төрөлтийг дэмжих, хүн амын насны тааламжтай бүтцийг урт хугацаанд тогтвортой хадгалах;
- Эдийн засаг, нийгмийн хөгжлийг хүн амын насны бүтцэд нийцүүлэн төлөвлөх замаар ахмад настанд ээлтэй амьдралын орчин бүрдүүлэх;
- Стратегийг хөгжлийн бодлого төлөвлөлтөд тусган хэрэгжүүлэх тогтолцоог бэхжүүлэх зэрэг болно.

Хүн амын насжилтын асуудлаарх Үндэсний стратеги нь

- Хүн амын насжилтыг угтах стратеги
- Ахмад настны аж байдлыг сайжруулах стратеги гэсэн 2 үндсэн бүрэлдэхүүн хэсэгтэй байх юм.

Насжилтыг угтах стратегийн зорилго нь хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн мэдрэмжтэй эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх замаар хөдөлмөрийн насны хүн амын ирээдүйн амьдралын баталгааг хангах явдал юм.

Угтах стратегид Монгол Улсын хөдөлмөрийн зах зээл, харилцаа, эрх зүйн орчны өнөөгийн байдал болон ирээдүйн чиг хандлагад дүн шинжилгээ хийж, стратегийн зорилт, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн чиглэл, удирдамж болох ерөнхий үйл ажиллагааг тодорхойлсон.

Ахмад настны аж байдлыг сайжруулах стратегийн хэсэгт ахмад настныг хөдөлмөр эрхлэх боломжоор хангах, орлогын

баталгаат түвшинд байлгах, ахмад настанд зориулсан эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, тэдэнд зориулсан дэд бүтцийг сайжруулах, насжилтын талаарх эерэг хандлага, зан үйлийг олон нийтэд төлөвшүүлэх, ахмад настны нийгмийн амьдралд оролцох, нийгмийн идэвхтэй гишүүн байх тааламжтай орчныг бий болгох зэрэг асуудлыг тусгав.

Стратегийн хэрэгжилт, зохион байгуулалтын хэсэгт түүнийг хэрэгжүүлэх, удирдлага, зохицуулалт, хяналтын тогтолцоог бүрдүүлэх, стратегийг хэрэгжүүлэхтэй холбоотой үндэсний чадавхи бэхжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээлэл судалгааг сайжруулах, санхүүжүүлэх асуудлыг тусгалаа.

Энэхүү стратеги нь хүн амыг насжилтын үйл явцад бэлтгэх, ахмад настны аж байдлыг сайжруулах талаар 2030 он хүртэл баримтлах урт хугацааны бодлогын чиглэл, ойрын болон дунд хугацаанд явуулах үйл ажиллагаа, авах арга хэмжээний үндэслэл болно.

## Зарчим

Насжилтын стратеги нь зөвхөн ахмад настны нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэхэд бус, хүн бүрийн амьдралынхаа туршид хөдөлмөрлөх, нийгмийн хамгаалалд хамрагдах, ахмад насанд шилжихдээ нийгмийн амьдралд идэвхитэй оролцож, нийгмийн гишүүний хувьд эрхээ эдлэхэд нь учирч болзошгүй саад бэрхшээлийг урьдаас арилгахад чиглэнэ. Стратегийг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Хүний эрхийг дээдлэх: Хүн бүр наснаасаа үл хамааран өөрсдийн өвөрмөц хэрэгцээнд тохирсон хөдөлмөр эрхлэх, сурч боловсрох, нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын амьдралд идэвхтэй оролцох, нийгмийн баталгаагаар хангагдах эрхтэй. Ахмад настан бүрт энэ эрхээ эдлэх боломжийг бүрдүүлэхийг эрмэлзэнэ.
- Оролцоо, хамтын ажиллагаанд түшиглэх: Хүн амын насжилтаас гарч болзошгүй сөрөг үр дагаврыг багасгах, түүнээс урьдчилан сэргийлэх, ахмад настны аж байдлыг дээшлүүлэх нь зөвхөн Засгийн газрын үүрэг биш бөгөөд

үүнд хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд, нийгэм, хамт олон чухал үүрэгтэйг харгалzan төр, иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагаа, түншлэлд тулгуурлана.

- Хэрэгцээнд суурилах: Ахмад настан нас, хүйс, үндэс угсаа, гэр бүлийн болон эрүүл мэндийн байдал амьжиргааны түвшин зэрэг хүчин зүйлсээс хамааран харилцан адилгүй хэрэгцээ, ашиг сонирхолтай байгааг бодлого үйл ажиллагаанд ахалзаж үзнэ.
- Насны бүтцэд суурилсан төлөвлөлтийг дэмжих: Хүн амын насны бүтэц, насжилтын явцыг үндэсний эдийн засаг, нийгмийн хөгжлийн урт, дунд хугацааны үндэсний болон салбар бүрийн бодлого, үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлэхийг чухалчилна.

## ХОЁР. НАСЖИЛТЫГ УГТАХ СТРАТЕГИ

Өнөөгийн хөдөлмөрийн насны хүн амын ажилгүйдлийг бууруулж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн чанарыг сайжруулж, нийгмийн даатгалд бүрэн хамруулах нь ирээдүйд ахмад настнууд баталгаатай, хангалттай орлоготой байх үндсэн нөхцөл болно. Иймээс насжилтыг угтах стратегийн хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, нийгмийн хамгааллыг сайжруулах, зохистой төрөлтийг дэмжиж, хүн амын насны тааламжтай бүтцийг урт хугацаанд тогтвортой хадгалах гэсэн гурван үндсэн зорилтыг дэвшүүлж байна.

### Зорилт 1. Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх

#### Өнөөгийн байдал

Монгол Улсын хүн ам 2008 оны жилийн эцсийн байдлаар 2683,5 мянга болоод байна. Үүний 62,9 хувийг хөдөлмөрийн насны хүн ам, 39,9 хувийг эдийн засгийн идэвхтэй хүн ам эзэлж байна. Үндэсний статистикийн хорооноос гаргасан хэтийн тооцоогоор 2015 он гэхэд хөдөлмөрийн насны хүн ам

206.5-212,0 мянгаар, эдийн засгийн идэвхтэй хүн ам 150.0-169.0 мянгаар нэмэгдэх төлөвтэй байна. Гэвч хөдөлмөрийн насны хүн амын өсөлтийг манай эдийн засаг шингээж чадахгүй байгаагаас ажил эрхлээгүй хүн амын тоо төдийлөн буурахгүй байна.

**Хүснэгт 2. Хөдөлмөрийн насны ажил эрхлээгүй хүн ам, шалтгаанаар, (2005-2008)**

|   | 2005   | 2006   | 2007   | 2008   |
|---|--------|--------|--------|--------|
| Ажил эрхэлдэггүй хөдөлмөрийн насны хүн ам | 260422 | 257615 | 261422 | 267489 |
| Хүндэтгэх шалтгаанаар ажил эрхэлдэггүй    | 95036  | 91369  | 96062  | 106277 |
| Бусад шалтгаанаар ажил эрхэлдэггүй        | 165386 | 166246 | 165380 | 161212 |
| Үүнээс /хувиар/                           | 100,0  | 100,0  | 100,0  | 100,0  |
| Ажил хайж байгаа                          | 37,7   | 38,4   | 43,8   | 45,7   |
| Тохирох ажил олдохгүй байгаа              | 25,0   | 23,1   | 23,4   | 20,9   |
| Засан хүмүүжүүлэх газраас суллагдсан      | 0,7    | 0,5    | 0,3    | 0,3    |
| Хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхолгүй         | 5,0    | 7,9    | 6,1    | 4,8    |
| Тодорхой шалтгаангүй                      | 31,5   | 30,0   | 26,3   | 28,4   |

Эх үүсвэр: Хүн амын ажил эрхлэлт, YCX, 2005-2008 он

Нөгөө талаар, хөдөлмөр эрхлэлтийн тоо чанарын үзүүлэлт хангалтгүй байна. Тухайлбал, албан секторт цалин хөлсөөр ажиллагчдын хувийн жин харьцангуй доогуур, албан бус сектор, хөдөө аж ахуйд ажиллагчдын эзлэх хувь өндөр байна. Чанаргүй ажлын байр, түүнийг дагасан бага цалин хөлс, ажилгүйдэл болон эдийн засгийн идэвхигүй байдлын өндөр түвшин зэрэг нь ирээдүйн ахмад настнуудын аж байдалд сөрөг үр дагавар авч ирж болзошгүй байна.

**Хүснэгт 3. Албан ба албан бус секторт ажиллагчдын тоо (2004-2008)**

| № | Үзүүлэлтүүд                  | 2004  | 2005  | 2006   | 2007   | 2008   |
|---|------------------------------|-------|-------|--------|--------|--------|
| 1 | Ажиллагчдын тоо              | 950.5 | 968.3 | 1009.9 | 1024.1 | 1041.7 |
| 2 | Үүнээс ХАА-д ажиллагчдын тоо | 381.8 | 386.2 | 391.4  | 385.6  | -      |

Эх үүсвэр: Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2008 он, YCX

**Хүснэгт 4. 15 ба түүнээс дээш насны хүн амын ажил эрхлэлтийн зарим үзүүлэлт**

|   |                                       | 2002-2003 | 2006-2007 |
|---|---------------------------------------|-----------|-----------|
| 1 | Гэрээгээр ажиллагч                    | 338.6     | 336.8     |
| 2 | Ажил олгогч                           | 5.5       | 6.0       |
| 3 | Хувираа хөдөлмөр эрхлэгч              | 303.4     | 306.4     |
| 4 | Өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогч | 215.0     | 249.7     |

Эх үүсвэр: Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан, 2004 он, YCG

### Шийдвэрлэх асуудал

Сүүлийн жилүүдэд манай улсын эдийн засаг харьцангуй өндөр өсөлттэй байсан ч тэр хирээр хөдөлмөр эрхлэлтийн түвшин нэмэгдээгүй байна. Энэ нь хөдөлмөр эрхлэлтийн мэдрэмж багатай уул уурхайн үйлдвэрлэл эдийн засгийн өсөлтөд давамгайлж байгаатай холбоотой. Тухайлбал, уул уурхайн үйлдвэрлэл хэвийн өсөлттэй байсан 2000-2003 онд хөдөлмөр эрхлэлтийн мэдрэмж хамгийн өндөр буюу ДНБ-ний өсөлтөөс түрүүлж байсан бол 2003 оноос хөдөлмөр эрхлэлтийн мэдрэмж суларч 2006-2009 онд 0.12 болтлоо буурсан байна.

Иймд боловсруулах үйлдвэрлэл, гар урлал, аялал жуулчлал, хүнсний үйлдвэрлэл зэрэг хөдөлмөрийн шингээлт ихтэй салбаруудыг өөрийн нөөц бололцоонд тулгуурлан хөгжүүлэх асуудлыг үндэсний хөгжлийн бодлогод тусган хэрэгжүүлж, хөдөлмөр эрхлэлтийн мэдрэмжийн түвшинг 0.3-0.5-д хүргэхийг зорих нь зүйтэй байна. Үүний зэрэгцээ ажиллагчдын хөдөлмөр эрхлэх ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх замаар бүтээмжийг нэмэгдүүлэх, дотоод, гадаад хөдөлмөрийн шилжих хөдөлгөөн, ажиллах хүчний урсгалыг зохистой удирдах, хөдөлмөрийн

харилцаанд уян хатан зохицуулалт нэвтрүүлэх зэргээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдлийг бууруулах явдал чухал байна. Түүнчлэн хүн ам насжихын хирээр залуу ажилчдын эзлэх хувь буурах хандлага нэмэгдэх учир чадварлаг ахмад ажилтны хөдөлмөр эрхлэлтийг зохистой хэлбэрээр дэмжиж, тэдний мэдлэг чадвар, ажил амьдралын туршлагыг үр дүнтэй ашиглах хэрэгцээ шаардлага бий болох учир үүнд эртнээс бэлтгэх шаардлагатай байна.

Нөгөө талаар ажиллагчдын дунд томоохон байр суурь эзэлж буй малчик, газар тариаланчид, албан бусаар хөдөлмөр эрхлэгчид зэрэг өрхийн аж ахуй болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг үйлдвэрлэл, хөдөлмөрийн зохион байгуулалтад оруулах замаар тасралтгүй орлоготой, тогтвортой ажлын байртай болгож хөдөлмөр эрхлэлтийн чанарыг сайжруулах явдал тулгамдсан зорилт болж байна.

### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

1. Хөдөлмөр эрхлэлтийн мэдрэмжтэй эдийн засгийн өсөлтийг дэмжих:

- Хөдөлмөрийн шингээлт ихтэй үйлдвэрлэлийг дэмжих, боловсруулах аж үйлдвэр, үйлчилгээний салбарын эдийн засагт эзлэх хувийг нэмэгдүүлэх;
- Хөдөөд жижиг дунд үйлдвэр, ялангуяа хөдөө аж ахуйн түүхий эд боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
- Бүлэг, хоршоо, нөхөрлөлийн зохион байгуулалтыг дэмжиж, малчик, тариаланчид, албан бус хөдөлмөр эрхлэгчдийг зохион байгуулалттай салбарт шилжүүлэх;
- Хөдөө аж ахуйн болон хөдөөд үйлдвэрлэсэн хүнсний бүтээгдэхүүний борлуулалтын сүлжээг хөгжүүлэх;
- Үйлдвэрлэл, хөдөлмөрийн харилцааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох замаар хөдөлмөрийн харилцаан дахь насаар ялгарварлах зэрэг таагүй байдлыг арилгаж, хөдөлмөр эрхлэлтийн тааламжтай уур амьсгал бүрдүүлэх;
- Ажилчдын мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх сургалтын тогтолцоог бэхжүүлж өндөр бүтээмж, цалин хөлстэй ажиллах бололцоог бүрдүүлэх.

2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих:

- Хөдөлмөрийн зах зээлд шинээр орж ирж буй залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх, дадлагажуулах хөтөлбөрийг өргөжүүлж, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;
- Тэргүүлэх салбаруудад ажлын байр нэмэгдүүлэх зорилтот хөтөлбөрүүдийг боловсруулж хэрэгжүүлэх;
- Хүн амын зорилтот бүлгүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх тусгай хөтөлбөрийг төрөөс санхүүжүүлэн хэрэгжүүлэх;
- Хөдөлмөрийн гадаад болон дотоод зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн гадаадад ажиллах хүч гаргах, дадлага туршлагатай болсон иргэдийнхээ эх орондоо буцаж ирж ажиллах сонирхлыг төрүүлэхүйц эрх зүй, эдийн засгийн арга хэмжээ авах.

### **Зорилт 2. Хөдөлмөр эрхэлж буй хүн амын нийгмийн баталгааг сайжруулах**

#### **Өнөөгийн байдал**

Өнөөдөр хөдөлмөр эрхэлж буй хүн амын 50 гаруй хувь нь иргэний эрүүл мэндийн даатгалаас бусад нийгмийн даатгалын төрөлд, ялангуяа, тэтгэврийн даатгалд хамрагдаагүй байна. Түүнчлэн эдийн засагт жижиг аж ахуйн нэгж, хувиараа эрхлэх аж ахуй, ажиллагчдын дунд зохион байгуулалтгүй салбарт ажиллагчид давамгайлж, тэдэнд нийгмийн даатгалын өнөөгийн тогтолцоо тохирохгүй байгаагаас олон мянган хүн хөдөлмөрийн наснаас гараадаа тэтгэвэргүй үлдэх байдалд байна.

Албан секторт цалин хөлсөөр ажиллагчид голдуу хамрагдаж байгаа өнөөгийн тэтгэврийн даатгалын тогтолцоо нь улсын төсвөөс татаастай, олгогдож буй тэтгэврийн хэмжээ нь амьжиргаанд хүрэлцээгүй, тэтгэвэр авагчдын дийлэнхи нь доод хэмжээний тэтгэвртэй байна.

Тэтгэврийн даатгалыг аажим шинэчлэх зорилгоор 1999 оноос тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны

тогтолцоог нэвтрүүлсэн бөгөөд 2015 оноос уг тогтолцооноос эхний даатгуулагчид тэтгэвэр олгож эхлэх боловч бэлтгэл бүрэн хангагдаагүй, цаашид амжилттай хэрэгжих эсэх нь ч эргэлзээтэй байна.

### **Шийдвэрлэх асуудал**

Хөдөлмөр эрхэлж буй хүн амыг нийгмийн даатгалд бүрэн хамруулж ирээдүйн нийгмийн баталгааг бий болгох, нийгмийн даатгалын тогтолцоог ахмад настны амьжиргаанд хүрэлцэхүйц тэтгэвэр олгох чадавхтай болгон бэхжүүлэх арга хэмжээг одооноос авахгүй бол 2030 он ба түүнээс цаашхи хугацаанд баталгаатай тэтгэвэргүй ахмад настны тоо олшрох, энэ хирээр нийгмийн халамжид болон тэтгэврийн санд зарцуулах хөрөнгө нэмэгдэх төлөвтэй байна.

Нийгмийн даатгалд хамрагдахгүй байгаа малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид зэрэг байнгын бус, тогтвортгүй бөгөөд бага орлоготой хэсгийг хамруулахын тулд тэдний үйлдвэрлэл, хөдөлмөрийн онцлогт тохирсон нийгмийн даатгалын тусгай тогтолцоог боловсруулж нэвтрүүлэх шаардлагатай байна.

Тэтгэврийн даатгалын өнөөгийн тогтолцоог боловсронгуй болгож, санхүүгийн бие даасан байдлыг сайжруулах замаар ахмад настны тэтгэврийн хэмжээг амьжиргааны наад захын хэрэгцээг хангахуйц түвшинд байлгах нь гол зорилт болж байна. Үүний зэрэгцээ хувь хүмүүс өөрсдийн санаачилгаар цалин хөлс авч, орлого олж байх үедээ ирээдүйн тэтгэврийн орлогоо баталгаажуулах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд тэтгэврийн нэмэгдэл болон хувийн даатгалын тогтолцоог хөгжүүлэх асуудал чухал юм.

Хөдөлмөрлөх чадваргүйн улмаас болон бусад шалтгаанаар хөдөлмөр эрхлээгүй, эсхүл эрхэлсэн хугацаа нь тэтгэвэр тогтолгох нөхцөлийг хангаагүй иргэд олшрох хандлагатай болж байна. Энэ нь өнөөгийн нийгмийн даатгалын болон халамжийн тогтолцооны дунд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн завсардан үлдэж, ядуу зүдүү амьдрах шалтгаан болж байна.

Өнөөгийн цалин хөлсний доогуур түвшингээс бодсон тэтгэвэр амьжиргаанд хүрэлцэхгүй байгаа учраас тэтгэвэр авагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор бий болгосон тэтгэврийн доод хэмжээний стандарт нь тэтгэврийн сангийн хөрөнгийн хуваарилалтад шударга бус байдлыг бий болгож байна. Иймээс тэтгэврийн доод хэмжээнээс татгалзаж, сангийн хөрөнгийн шударга хуваарилалтын зарчим мөрдөх, ахмад настны эрхийг хүндэтгэх, өнөөгийн авч буй тэтгэврийн хэмжээг бууруулахгүй байх үүднээс хүн бүрт ижил хэмжээгээр олгогдох универсаль тэтгэврийг татвар дээр суурилсан хэлбэрээр нэвтрүүлэх, олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжих нь ирээдүйн ахмадуудад чухал ач холбогдолтой болж байна.

Түүнчлэн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны үлдэгдлийн тодорхой хэсгийг эргэлтэд оруулж, ирээдүйд уг данснаас тооцох тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, ашигт малтмалын томоохон ордуудыг ашигласнаас олох орлогын тодорхой хэсгээр хуримтлалын сан байгуулах замаар алсдаа төсөв дээр ирэх тэтгэврийн ачааллыг бууруулах арга хэмжээг одооноос төлөвлөж хэрэгжүүлэх нь насжилтыг угтах гол утвар нөхцөл болно .

### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

1. Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх:
  - Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгч зэрэг байнгын бус, тогтвортгүй бөгөөд бага орлоготой хэсэгт зориулсан тэтгэврийн даатгалын тусгай тогтолцоог бий болгох хууль эрх зүйн орчин бүрдүүлэх, энэхүү тогтолцоонд дээрх бүлгийн иргэдийг урамшуулалтайгаар хамруулах;
  - Улсын тэтгэврийн даатгалын тогтолцоогоор хангалттай тэтгэвэр авах боломж нь хязгаарлагдаж байгаа өндөр цалин хөлстэй хүмүүст тэтгэвэрт гарагдаа бусдаас илүү хангамжтай байх нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор нэмэгдэл болон арилжааны тэтгэврийн тогтолцоог шинээр бий болгох;
  - Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн доод хэмжээг мөрдөхгүй болгож, тэтгэврийн сангийн

- хуваарилалтын шударга зарчим тогтоох;
- Хүн бүрт ижил хэмжээгээр олгогдох универсаль тэтгэврийг нэвтрүүлэх замаар нийгмийн хalamжийн тэтгэврийг аажимдаа солих;
  - Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тогтолцоог боловсронгуй болгох.

2. Ирээдүйд өсөн нэмэгдэх нийгмийн хамгааллын зардлыг санхүүжүүлэх хөрөнгийн баталгаат эх үүсвэрийг бүрдүүлэх:

- Улсын төсвөөс тэтгэврийн даатгалын сангийн нэрийн дансанд буцаан байршуулах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх;
- Тэтгэврийн даатгалын сангийн нэрийн дансны хөрөнгийн менежментийн хууль эрх зүйн орчинг бүрдүүлж, сангийн хөрөнгийг арвижуулах арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Ирээдүйн тэтгэврийн сангийн ачааллыг бууруулах чиглэлээр тэтгэврийн ухаалаг шинэчлэлийг хэрэгжүүлэх;
- Стратегийн ач холбогдол бүхий томоохон орд газруудаас олсон орлогын тодорхой хэсгээр хуримтлалын сан байгуулах, уг сангийн орлогоос ирээдүйд нэмэгдэх тэтгэврийн зардлыг санхүүжүүлэхтэй холбоотой хууль эрх зүйн орчин бүрдүүлэх;
- Санхүүгийн бусад эх үүсвэрийг хайх.

### **Зорилт 3. Зохистой төрөлтийг дэмжиж хүн амын насны тааламжтай бүтцийг урт хугацаанд тогтвортой хадгалах**

#### **Өнөөгийн байдал**

Манай улсын хүн амын өсөлтийн хурд 1990-ээд оноос 2006 оныг хүртэл байнга саарсан хэдий ч, сүүлийн 3 жилд төрөлт бага зэрэг нэмэгдэж байна. Төрөлтийн нийлбэр коэффициент 1990 онд 4.5 байснаа 2000 онд хоёр дахин буурч 2.2, 2005 онд 1.9 болсон ба 2007 оны эцэст 2,3 болж өсчээ. Хүн амын төрөлт буурч, гадаад шилжих хөдөлгөөн нэмэгдсэн нь өсөлтийг сааруулах гол хүчин зүйл болж байна.

НҮБ-аас хийсэн хэтийн тооцоогоор 2000 онд 2,4 сая байсан

Монгол Улсын хүн ам 2050 онд 3,4 сая болж нэмэгдэхээр байна. Бодлогын ямар нэг нөлөөлөлгүйгээр энэ үеийн чиг хандлага цаашид үргэлжилбэл хүн амын жилийн дундаж өсөлт 2030-2050 онд 0.6-0.1 хувь болж буурахаар байна.

| Хүснэгт 5. Хүн амын насны бүтэц, өсөлтийн хурд, төрөлтийн коэффициентүүд, 2010-2050 он |        |        |        |        |        |        |        |        |        |
|--|--------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|
|  | 2010*  | 2015*  | 2020*  | 2025*  | 2030*  | 2035** | 2040** | 2045** | 2050** |
| 0-14 насны хүүхдийн тоо (мянга)  | 397.3  | 419.6  | 425.3  | 412.3  | 396.5  | 201.99 | 200.49 | 197.27 | 190.99 |
| 5-14 насны хүүхдийн тоо (мянга)  | 253.9  | 274.0  | 287.2  | 283.6  | 267.0  | 419.97 | 404.74 | 399.05 | 394.62 |
| 15-24 залуучуудын тоо (мянга)  | 295.0  | 258.7  | 252.2  | 271.8  | 286.1  | 462.49 | 441.71 | 416.38 | 401.42 |
| 15-49 насны эмэгтэйчүүд (мянга)  | 1628.5 | 1673.1 | 1735.5 | 1808.6 | 1870.8 | 830.99 | 782.75 | 748.28 | 735.61 |
| Жилийн дундаж өсөлт (хувь)   | 1.5    | 1.3    | 1.2    | 1.0    | 0.9    | 0.46   | 0.35   | 0.22   | 0.08   |
| Төрөлтийн нийлбэр коэффициент  | 2.32   | 2.24   | 2.08   | 2.00   | 2.00   | 1.85   | 1.85   | 1.85   | 1.85   |

Эх үүсвэр: \* Монгол Улсын хүн амын 2008-2030 оны хэтийн тооцоо

\*\* <http://data.un.org/Browse.aspx?d=PopDiv>, Хэтийн тооцооны дунд хувилбар

2020 оноос 2000-аад онд төрсөн эмэгтэй хүүхдүүд нөхөн үржихүйн насанд, 1960-1980 оны өндөр төрөлтийн үеийн хүүхдүүд тэтгэврийн насанд шилжих үе бөгөөд энэ үеэс ахмад настны хүн ам зүйн ачаалал байнга нэмэгдэх төлөв ажиглагдаж байна. Тухайлбал, 2000 онд 65, түүнээс дээш насныхы хувийн жин 3.6 хувь байсан бол 2025 онд 6.37 хувь, 2050 он гэхэд 17.4 хувь буюу даруй 5 дахин нэмэгдэхээр байна. Ахмад настны ачаалал 2000 онд 6 байсан бол 2050 онд 26.5 болж өсөх, хүүхдийн ачаалал 2000 онд 59 байснаа 2050 онд 26.6 болж буурах тооцоо гарч байна. Түүнчлэн 15-39 насны хүн амын хувийн жин аажим буурч, 40-өөс дээш насныхы нийт хүн амд эзлэх хувь өсөхөөр байна.

Тодорхой хугацааны дараа хүн амын насны бүтцэд гарах энэ таагүй өөрчлөлтийг сааруулахад чиглэсэн бодлого, үйл

ажиллагааг одооноос эхлэн хэрэгжүүлэхгүй бол хүн амын насжилтаас үүдэлтэй тэтгэврийн болон эрүүл мэндийн даатгалын ачаалал мэдэгдэхүйц нэмэгдэхийн зэрэгцээ эдийн засагт хөдөлмөрийн нөөц, ажиллах хүч дутагдаж болзошгүй байна.

## Шийдвэрлэх асуудал

"Хүн ам зүйн цонх"-ны үе богино, ихэнхдээ 20-30 жил үргэлжилдэг бөгөөд манай орны хувьд энэ үе 2000-2030 онуудад ажиглагдаж байна. Үүнээс цаашхи хугацаанд хөдөлмөрийн насны хүн амын нийт хүн амд эзлэх хувийн жин аажмаар буурч улмаар насжилттай холбоотой тулгамдсан асуудлууд гарах болно.

Хүн ам зүйн цонхны үеийн тааламжтай нөхцөлийг тогтвортой хадгалахын тулд төрөх насны эмэгтэйчүүдийн тоо оргил цэгтээ байгаа өнөөгийн таатай үеийг ашиглан хүн амын зохистой өсөлтийг дэмжих ирээдүйн хөдөлмөрийн нөөцийг нэмэгдүүлэх, ахмад настны хүн ам зүйн ачааллыг бууруулах бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь чухал байна.

Хүн амын төрөлтийг нэмэгдүүлэхийн тулд гэр бүлийн амьдралын таатай орчинг бүрдүүлж, амьдралын баталгааг хангах явдал чухал юм. Бусад улс орны туршлагаас үзвэл гэр бүлийн гишүүдэд ажил хөдөлмөрийн зэрэгцээ үр хүүхэд төрүүлж, өсгөх боломжийг бүрдүүлэх, ажил амьдралын үүрэг хариуцлагыг тэнцвэржүүлэх асуудлыг зохистой шийдвэрлэх нь хүн амын төрөлтийг дэмжих талаар амжилт олох үндэс болж байна.

## Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

### 1. Төрөлтийг урамшуулж, гэр бүлийг дэмжих:

- Хүн амын эргэн нөхөгдөх түвшинг хангах, төрөлтийг урамшуулах зорилгоор гурав дахь хүүхдээ төрүүлсэн гэр бүлд мөнгөн урамшуулал /baby bonus/ олгох асуудлыг судалж хэрэгжүүлэх;

- "Хүүхдийн мөнгө" хөтөлбөрийг эцэг, эхийн орлогын түвшин, хүүхдийн насны онцлогтой уялдуулан зохистой хэлбэрээр өөрчилж, хүүхдийн хэвийн өсөлт хөгжлийг дэмжихэд хувь нэмэр оруулах.

### 2. Гэр бүлд ээлтэй хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын үйлчилгээг дэмжих:

- Хүүхэд төрүүлсэн эх, хүүхдээ асарч буй эцгийн ажлын байрыг хадгалах, орлогынх нь тодорхой хувийг нөхөн олгохтой холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болгох, эдийн засгийн хөшүүргийг бий болгох;
- Бага насны хүүхэдтэй эцэг эхчүүдийг ажил эрхлэх боломжоор хангах зорилгоор аж ахуйн нэгж байгууллагуудад ажилчдынхаа хүүхдийг асрах үйлчилгээ, хөдөлмөр зохион байгуулалтын уян хатан зохицуулалт нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Эцэг эхийн аль алинд ажил, албан тушаалын болон гэр бүлийн үүрэг хариуцлагаа адил тэгш гүйцэтгэх боломж олгосон хөдөлмөрийн зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалт, эдийн засгийн урамшуулал бий болгох;
- Бага насны хүүхдийг асран, халамжлах үйлчилгээний нэр төрлийг (цагийн, хагас өдрийн, өдрийн үйлчилгээ гэх мэт) нэмэгдүүлэх, энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэгчдийг татвар, зээл, санхүүгийн бодлогоор дэмжих.

### 3. Гэр бүлийн таатай орчин бүрдүүлэх:

- Гэр бүл З ба түүнээс дээш хүүхэдтэй байх, хүүхдээ эрүүл, саруул өсгөн бойжуулах, боловсрол, хүмүүжлийн зөв төлөвшил олгох чиглэлээр гэр бүлийг дэмжих;
- Залуу гэр бүлийн бие даан амьдрах нөхцлийг бүрдүүлэх, орон сууцны нөхцлөө сайжруулахад дэмжлэг үзүүлэх тогтвортой, үр ашигтай тогтолцоо бүрдүүлэх;
- Олон хүүхэдтэй гэр бүлийг дэмжих эдийн засгийн хөшүүрэг, орон сууцны дэмжлэг үзүүлэх механизмыг бий болгох;
- Гадаадад ажиллаж байгаа залуучуудыг гэр бүлтэйгээ хамт байх боломжийг бүрдүүлэх, эх орондоо дутагдалтай мэргэжил, дадлагаа эзэмшсэн залуучуудын буцаж ирэх

- сонирхлыг төрүүлэх эдийн засгийн урамшуулал, хөшүүрэг бий болгох;
- Гэр бүлд зөвлөгөө өгөх үйлчилгээг хөгжүүлэх, гэр бүлтэй ажиллах нийгмийн ажлыг хөгжүүлэх.

## **ГУРАВ. АХМАД НАСТНЫ АЖ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ СТРАТЕГИ**

Ахмад настан нь нийгмийн эрх тэгш, идэвхтэй гишүүний хувьд баталгаатай орлоготой байж, хэрэгцээтэй эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээг хүртэж, гэр бүл, нийгэм, хамт олны дунд утга төгөлдөр амьдрах эрхтэй билээ. Тиймээс тэдэнд хөдөлмөр эрхлэх таатай боломжийг бий болгох, нийгмийн хамгааллыг сайжруулах, эрүүл насжих, нийгэм, олон нийт, гэр бүлийнхээ дунд эрх тэгш амьдрах ээлтэй орчинг бүрдүүлэх замаар тэдний амьдралын чанарыг сайжруулахад чиглэсэн дараах зорилтыг дэвшүүлж байна.

**Зорилт 1. Ахмад настны хөгжилд оролцох оролцоог хангах, түүний үр шимээс хүртэх боломжийг өргөжүүлэх замаар тэдний орлогын баталгаат байдлыг сайжруулна.**

### **Өнөөгийн байдал**

Монгол Улсын хуулиар 60 нас хүрсэн хүн өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрхтэй боловч амьжиргааны түвшин, ажиллах чадвар, хүсэл эрмэлзлээс хамаарч, үргэлжлүүлэн ажиллах явдал байсаар байна. Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын үр дүнгээс үзвэл 60 ба түүнэс дээш насны 8 хүн тутмын нэг нь ямар нэгэн ажил эрхэлж байна.

Өрхийн нийгэм, эдийн засгийн 2007-2008 оны судалгаагаар хүн амын 35.2 хувь нь ядуурлын шугамнаас доогуур түвшинд амьдарч байгаа бөгөөд эдгээр өрхийн тэргүүлэгчдийн 12 орчим хувь нь 60 ба түүнээс дээш насныхан байна. Ахмад настан тэргүүлэгчтэй өрхийн амьжиргааны гол эх үүсвэр нь нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн сангаас олгодог

тэтгэвэр, хөдөлмөр эрхлэлтээс олсон орлого (ялангуяа хөдөө орон нутагт малmallах гэх мэт) болон үр хүүхдүүдээс ирүүлж буй мөнгөн гүйвуулга байна.

2008 оны жилийн эцсийн мэдээгээр Нийгмийн даатгалын сангаас 293.4 мянган хүн тэтгэвэр, тэтгэмж авснаас 65.9 хувь нь өндөр насны тэтгэвэр авагч байна. Нэг хүнд ноогдох дундаж тэтгэврийн хэмжээ 2008 оны байдлаар 96.4 мянган төгрөг байна. Харин ажил хөдөлмөр эрхэлдэггүй байсан буюу нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авах эрх үүсээгүй нэн ядуу амьдралтай, ганц бие ахмад настанд нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр тэтгэмж олгож, тус сангаас авч буй өндөр насны тэтгэврийн дундаж хэмжээ нь даатгалын сангаас олгодог доод тэтгэврийн 1/2 тэй ойролцоо түвшинд буюу 41.4 мянган төгрөг байна.

Хүн амын нийгмийн даатгалд хамрагдлалт хангалтгүй байна. 2008 оны жилийн эцсийн байдлаар 15-59 насны 1740.8 мянган хүн байгаагийн 34.5 хувь буюу 602.2 мянган хүн заавал болон сайн дураар цалин орлогоосоо нийгмийн даатгалын санд шимтгэл төлж, ирээдүйд авах тэтгэврээ хуримтлуулж байна.

Өнөөгийн байдлаар монгол эрэгтэйчүүд дунджаар 13.3 жил, эмэгтэйчүүд 15.3 жил тэтгэвэр авч байгаа бол 2030 оноос хойш хүн амын тэтгэвэр авах дундаж хугацаа эрэгтэйчүүдэд 15.4 жил, эмэгтэйчүүдэд 17.1 жил болж өсөх, улмаар ахмад настан хүн амын тоо огцом нэмэгдэх төлөвтэй байна. Энэ үед нийгмийн даатгалын санд хуримтлагдсан хөрөнгө нь ахмад настанд олгох ёстой тэтгэврийн ачааллаа даахгүйд хүрч, удаан хугацааны туршид санхүүгийн бэрхшээлтэй тулгарч болзошгүй юм. Түүнчлэн хүн амын насжих үйл явцын үр дагавар болох нийгмийн халамж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардал нэмэгдэх болно.

### **Шийдвэрлэх асуудал**

Ахмад настан өөрийн чадавхидаа тохирсон ажлыг тааваараа эрхлэх боломж хомс байна. Ахмадууд хөдөлмөрийн хатуу

зохион байгуулалт, горимд захирагдсан, өөрийн чадамж, чадвараас ахадсан, өөрийн хуримтлуулсан мэдлэг, чадвар, дадлагыг нийгэм, хамт олонд тустай хэлбэрээр ашиглаж чадахгүй, наад захын энгийн ажил эрхлэх замаар нэмэгдэл орлого олж байна. Иймд тэдэнд мэдлэг чадвартaa тохирсон ажлыг уян хатан зохион байгуулалттайгаар эрхлэх, эсхүл өөрсдийн санаачилгаар аж ахуй эрхлэх, мэдлэг чадвараа залуу үедээ өвлүүлэх замаар хөгжилд хувь нэмрээ оруулж, орлогоо нэмэгдүүлэх боломж олго шаардлагатай байна.

Түүнчлэн нийгмийн баялгийн дахин хуваарилалтыг оновчтой болгох замаар ахмад настныг улс орны хөгжил, эдийн засгийн өсөлтөд оруулсан хувь нэмрийг шударга үнэлэх зарчмаар тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг амьжиргаанд хүрэлцэхүйц хэмжээнд байлгах, тэдний насны онцлог, өвөрмөц хэрэгцээнд нийцсэн нийгмийн хамгааллын үйлчилгээг хүртээмжтэй хүргэх явдал чухал байна.

### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

1. Ахмад настны боломж, чадавхидаа тохирсон ажил, ахуй эрхлэх санаачилгыг дэмжин тусална:

- Ахмад настныг хөдөлмөрийн харилцаанд оролцоход тулгарч буй саад бэрхшээлийг арилгах, тэдэнд зориулсан уян хатан зохион байгуулалт, хөдөлмөрийн горим бүхий ажлын байр бий болгохыг дэмжих эдийн засаг, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах;
- Ахмад настны мэргэжил, дадал туршлагыг ашиглах зорилгоор ахмад ажилтнаас бүрдсэн зөвлөх баг, бүлэг байгуулан ажиллуулах санаачилгыг дэмжих;
- Аж ахуй нэгж байгууллага дахь сул чөлөөтэй ажлын байранд ажиллах боломжтой ахмад настныг зуучлах, тэднийг мэргэжил, ур чадвараа дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх;
- Ахмад настнуудыг сайн дурын үндсэн дээр бүлэг, хоршоо байгуулан ажиллуулахад зохион байгуулалт, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, зарим ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх;

- Ахмадуудын өөрсдийн байгуулсан болон ахмад настан олноор ажилладаг, ахимаг болон ахмад насны ажилтан дадлага, ур чадвараа залуу үед өвлүүлэх боломжийг бүрдүүлэх талаар санаачилгатай ажиллаж байгаа аж ахуйн нэгжийг төрөөс эдийн засаг, санхүүгийн механизмаар урамшуулах;
- Бизнес эрхлэх ур чадвар эзэмшүүлэх, дэвшилтэт техник технологи ашиглах сургалтыг тэтгэврийн өмнөх насыхан болон ахмад настнуудад зориулан зохион байгуулах.

2. Нийгмийн баялгийн дахин хуваарилалтыг оновчтой болгох замаар ахмад настны тэтгэвэр тэтгэмж, нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ:

- Нийгмийн даатгалын болон халамжийн сангаас ахмад настанд олгож буй тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг амьжиргааны өртийн өөрчлөлт, инфляцийн түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх талаар дэс дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Нийгмийн халамжийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, төрөл хэлбэрийг олшруулж, ахмад настны сонголт хийх боломжийг өргөжүүлэх;
- Төрөлжсөн асрамжийн болон олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг зохистой хослуулах замаар асрамж шаардлагатай ахмадуудад гэрийн болон түүнтэй адил нөхцөлд нийгмийн халамжинд байх нөхцлийг бүрдүүлэх
- Ахмад настанд зориулсан асрамжийн үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгжийг урамшуулах, хувийн халамж, асрамжийн үйлчилгээг хөгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх
- Ахмад настныг гэрээр асрах, нөхөн сэргээх, тэдэнд туслах, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх нийгмийн болон сайн дурын ажилтны үйлчилгээг өргөжүүлэх
- Ахмад настныг эрүүл мэнд, нийтийн тээврийн болон холбогдох бусад нийгмийн үйлчилгээнд хөнгөлөлттэйгээр хамруулах

**Зорилт 2. Хүн амыг эрүүл насжихад бэлтгэх, эрүүл мэндийн мэдээлэл сурталчилгаа, тусlamж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах замаар ахмад настны өвчлөлийг бууруулна.**

### **Өнөөгийн байдал**

Хүн ам эрүүл насжих, ахмад настны нийгэм, хамт олон, гэр бүл дотроо идэвхтэй амьдрахын үндэс суурь нь тэдний насан туршдаа эрүүл байх явдал билээ. Судалгаанаас үзвэл 70 ба түүнээс дээш насанд цусны даралт ихсэх, зүрх судасны архаг өвчин түгээмэл тохиолдож байна. Ахмадууд зөвхөн өвчилсөн үедээ өрхийн эмнэлэгт хандаж, З хүн тутмын нэг нь хэвтэж эмчлүүлдэг бол гуравны нэгээс илүү нь мөнгөний боломжгүй, эрүүл мэндийн үйлчилгээнээс хол гэсэн шалтгаанаар эмнэлэгт хэвтэж чадахгүй байна. Ахмад настан бүр эрүүл мэндийн үйлчилгээг тэгш хүртэж чадахгүй байгаагийн дээр урьдчилан сэргийлэх үйлчилгээний хүртээмж хангальгүй байна.

Ахмад настны эрүүл мэндийн байдал нь эзэмшсэн боловсрол, амьдралын хэв маяг зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалах боловч хот хөдөөгийн ялгаа, дэд бүтцийн хөгжил, үйлчилгээнд хүрэх боломж, хувь хүний зүгээс насжилтад биеэ бэлтгэх чадвар, өөрийгөө авч явах сэтгэл зүйн бэлтгэл зэрэг чухал ач холбогдолтой юм.

### **Шийдвэрлэх асуудал**

Сүүлийн жилүүдэд хүн амын дундаж наслалт уртсаж байгаа учир ахмад настан эрүүл байж, нийгэм, эдийн засгийн хөгжилд өөрийн хувь нэмрээ оруулж, идэвхтэй амьдрах нь өөртөө болон гэр бүлдээ аз жаргал өгөөд зогсохгүй нийгмийн үйлчилгээнд нэмэгдэл ачаалал үүсэхээс урьдчилан сэргийлэх чухал ач холбогдолтой юм.

Хэдийгээр хүний эрүүл мэндийн байдалд биологи, нийгэм, эдийн засаг, гэр бүлийн болон бусад олон хүчин зүйл нөлөөлөх боловч хувь хүний өөртөө тавих анхаарал хalamж,

өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх чадвар, зан үйлийг төлөвшүүлснээр өвчлөл, бэртэлт, хөдөлмөрийн чадвар алдалт зэрэг тохиолдлыг мэдэгдэхүйц бууруулах боломж байна.

Тиймээс ахмад настны дунд зонхилон тохиолддог өвчнөөс сэргийлэх зан үйлийг төлөвшүүлэх, тэдний эрүүл мэнддээ тавих хяналтыг сайжруулах, эрсдлээс хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа, эрүүл насжихад бэлтгэх арга хэмжээг өргөжүүлэх, тогтмолжуулах хэрэгтэй байна.

Энэ зорилгоор ахмад настанд эмнэлгийн тусlamж авахад тулгарч буй саад бэрхшээлийг арилгах, эрүүл мэндийн үйлчилгээг тэгш хүртэх боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ тэдэнд өвчлөл, бэртлээс урьдчилан сэргийлэх чадвар, соёл эзэмшүүлэх асуудал чухлаар тавигдаж байна.

### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

1. Хүн амыг эрүүл насжихад бэлтгэх:

- Тэтгэврийн нас дөхсөн ажиллагчдыг тэтгэвэрт гарах сэтгэл зүйн бэлтгэлийг эртнээс хангах, тэдэнд тусгайлан зориулсан эрүүл аж төрөх чадвар олгох сургалтад хамруулах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг хөгжүүлэх;
- Ахмадуудын эрүүл насжих, бие махбодь, сэтгэл зүйн хувьд эрүүл, тайван, аюулгүй амьдрах хүрээлэн буй орчинг бүрдүүлэх зорилгоор хот суурин газруудад цэцэрлэгт хүрээлэн, нийтийн амралтын талбай байгуулах;
- Хүн амыг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт оношлоход чиглэсэн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг өргөжүүлэн, ахмад настныг байнгын хяналтад байлгах;
- Ахмад настнуудын дунд биеийн тамир, дасгал хөдөлгөөнөөр хичээллэх явдлыг дэлгэрүүлэх, бие бялдараа хөгжүүлэх, чийрэгжүүлэх техник хэрэгсэл, тоноглолыг орон сууц, нийтийн эзэмшлийн талбай, зугаалга, амралтын газруудад байрлуулж, хүртээмж, хэрэглээг нэмэгдүүлэх;
- Насжилтын улмаас биед үүсэх эмгэг, өвчлөлөөс

урьдчилан сэргийлэхэд шаардлагатай нэмэгдэл бүтээгдэхүүний хүрэлцээг сайжруулах, түүнийг хэрэглэх соёлыг төлөвшүүлэх, эрүүл мэндээ хамгаалах, гамшиг, осол гэмтлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах зан үйлийг төлөвшүүлэх.

## 2. Эмнэлгийн тусlamж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах:

- Ахмад настанд зориулсан урт хугацааны эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний шинэ хэлбэрийг бий болгох, ялангуяа, сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээг өргөжүүлэх;
- Ахмад настанд насжилтын улмаас үүсч буй зарим өвчлөлийн үед хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгсэл болон эрүүл мэндийн наад захын тусlamж үйлчилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас бүрэн болон хэсэгчлэн төлөх эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
- Хувийн хэвшлийн амралтын газар, хосписс, рашаан сувилал, сувилахуйн газарт ахмад настны боломжид тохирсон үнэ төлбөртэйгээр үйлчилгээ үзүүлэх нөхцлийг бүрдүүлэх;
- Эрүүл мэндийн байгууллагууд ахмад настныг эрүүл мэндийн иж бүрэн үйлчилгээнд хамруулах өрөө тасалгаа, тоног төхөөрөмж, хөтөч үйлчилгээний ажилтан бий болгох зэрэг тусгай арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- Ахмад настан хаягийн бүртгэл, иргэний харьяаллаас үл хамааран эрүүл мэндийн тусlamж үйлчилгээнд хамрагдах боломжийг бүрдүүлэх;
- Хөдөө орон нутаг, алслагдсан нутагт амьдарч бий ахмад настанд явуулын эрүүл мэндийн үйлчилгээ, лабораторийн шинжилгээг хүргэх тогтолцоог бүрдүүлэх;
- Стандартын дагуу тоноглогдсон, мэргэшсэн боловсон хүчин бүхий гериатрийн кабинетыг хоёр болон гурав дахь шатны эмнэлэгт байгуулах.

**Зорилт 3. Олон нийтэд ахмад настны талаарх эерэг ойлголт, хандлагыг төлөвшүүлж, тэднийг гэр бүл, нийгэм, хамт олны дунд ажиллаж, амьдрах, харилцан бие биедээ туслах, утга төгөлдөр амьдрах ээлтэй орчинг бүрдүүлнэ.**

## Өнөөгийн байдал

Ахмад настны сэтгэл ханамж нь тэдний гэр бүл, нийгэм хамт олонтойгоо ойр дотно, холбоотой байх, нийгмийн идэвхтэй, хүндтэй гишүүн гэдгээ мэдэрч, хүндлэл хүлээх үйлдлээр илэрч байна.

Манай нийгэмд ахмад настны гэр бүл, үр хүүхдийнхээ хүрээнд хүлээх хүндлэл, хайр халамж уламжлагдан ирсэн хэдий ч нийгмийн хөгжилд гүйцэтгэсэн үүрэг, хувь нэмрийн талаарх эерэг ойлголт, хандлага олон нийтийн дунд нийтлэг бус нь ахмадуудын хүсэл эрмэлзлийг дутуу үнэлэхэд хүргэж байна.

Ахмад настан урьдын адил гэр бүл, нийгэм хамт олны амьдралд оролцох, идэвхтэй амьдрах, бие даасан байдлаа хэвээр хадгалахад нийгэм, хамт олны зүгээс үзүүлэх эерэг хандлага чухал нөлөөтэй. Түүнчлэн ахмад настны нийгмийн амьдралд идэвхтэй оролцоход тэдний амьдарч буй орчин нөхцөл, тээвэр, харилцаа холбоо, дэд бүтцийн хөгжил зэрэг хүчин зүйлс тодорхой хэмжээгээр нөлөөлж байна.

Ахмад настны ахуй амьдрал, орон байр, амьдрах орчин, нөхцлийг нь сайжруулах, тэдний ая тухтай амьдрах боломжийг хангах талаар төрөөс төрөл бүрийн арга хэмжээ, ажил үйлчилгээг өргөжүүлэх талаар багагүй арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа боловч ахмад настан бүр элбэг хангалиун, сэтгэл дүүрэн байх боломж бүрдээгүй байна. Түүнчлэн ахмад настны гэр бүл, орон сууц, оршин суух орчныг тэдний онцлог хэрэгцээнд нийцсэн, эрүүл ахуйн шаардлага хангасан байхаар зохион байгуулах, ахмад настанд ээлтэй дэд бүтцийг бий болгох, хөгжүүлэх асуудал дутмаг хэвээр байна.

## Шийдвэрлэх асуудал

Хүн амын наслалт уртасч, ахмад настны тоо нэмэгдэх хирээр тэдний идэвхтэй амьдрах орчинг бүрдүүлэх, нийгмийн амьдралд оролцох боломжийг хангах шаардлага урьд урьдаас илүү нэмэгдэж байна.

Ялангуяа, ахмад настныг нийгэм, хамт олон, найз нөхөд, гэр булийнхнийнхээ дунд амар тайван байх, нийтийн тээвэр, үйлчилгээний газраар саадгүй үйлчлүүлэх боломжийг бүрдүүлж, аюулгүй, найдвартай, өртөг багатай, тохилог орон байраар хангах явдал тэднийг утга төгөлдөр амьдарч, хөгжихийн үндсэн нөхцөл болж байна.

Түүнчлэн хот хөдөөд ахмад настан, ялангуяа, хөгжлийн бэрхшээлтэй ахмадуудын онцлог хэрэгцээнд тохирсон нийтийн үйлчилгээг сайжруулах замаар тэдний нийгмийн амьдралд оролцох, хөгжлийн үр шимийг хүртэх боломжийг бүрдүүлэх явдал чухал байна.

Ахмад настны мэдээлэл харилцааны технологийн хөгжилд дасан зохицож, гэрээрээ мэдээлэл, үйлчилгээ авах, суралцах, ур чадвараа хөгжүүлэх өргөн боломжийг өргөжүүлэх шаардлага орчин үеийн амьдралаас урган гарч байна.

### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

1. Насжилт, ахмад настны талаар олон нийтийн дунд эерэг ойлголт хандлагыг төлөвшүүлэх замаар тэднийг гэр бүл, нийгэм хамт олныхоо дунд амар тайван амьдрах ээлтэй орчинг бүрдүүлнэ:

- Ахмад настныг ажиллаж байсан аж ахуйн нэгж байгууллагатайгаа байнгын холбоотой байж, ажил амьдралын туршлагаа дараа үеийнхэнтэйгээ хуваалцах, тэдэндээ хүндлэгдэж байх нөхцлийг бүрдүүлэх;
- Гэр бүл, үр хүүхэд, садан төрлийнхөн нь ахмад настнаа хүндлэх, гэр бүл, нийгэмд гүйцэтгэсэн үүргийг нь эерэгээр үнэлэх зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн Ургийн баяр, алт, мөнгөн хурим, насны ой тэмдэглэх зэрэг уламжлалт зан заншил, баяр ёслолыг тэмдэглэхийг хөхиүүлэн дэмжих;
- Гэр бүлийн харилцааны уламжлалт ёс заншил, ялангуяа, аав ээж, ахмад настнаа гэр бүлдээ асран халамжлахын давуу талыг олон нийтэд сурталчлах, энэ соёлыг төлөвшүүлэх;
- Ахмад настан бүлэг, холбоо, клуб байгуулах замаар бие

биедээ туслах, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох санал санаачлагыг дэмжих, урамшуулах тогтолцоог бүрдүүлэх;

- Төрийн бүх шатны байгууллагын дэргэдэх зөвлөл, хороодод ахмадуудын төлөөллийг мэргэжил, туршлагынх нь дагуу ажиллуулах, эсхүл ахмад ажилтнуудтайгаа зөвлөлдөх ажлыг зохион байгуулах замаар шийдвэр гаргах үйл явцад ахмад настны оролцоог нэмэгдүүлэх;
- Ахмад настны дунд урлаг, спорт, соёлын арга хэмжээг тогтмол зохион байгуулах, ялангуяа алслагдсан нутагт амьдарч буй болон хөгжлийн бэрхшээлтэй ахмадуудыг түүнд оролцох боломжийг хангах, энэ талаарх мэдээллийг өргөжүүлэх;
- Ахмадуудад ашигтай мэдээлэл бүхий тогтмол нэвтрүүлгийн цаг, суваг зэргийг үндэсний олон нийтийн радио, телевизэд бий болгох.

2. Ахмад настны орон байрны хангамжийг сайжруулах, тэдний онцлог хэрэгцээнд нийцүүлэн орчны дэд бүтэц, тээвэр, үйлчилгээг хөгжүүлнэ:

- Ахмад настны өвөрмөц хэрэгцээнд нийцэн тоноглол төхөөрөмж бүхий хямд төсөр, өртөг багатай нийтийн орон сууц, түрээсийн байрыг барьж байгуулах, энэ хэлбэрийн байруудын ойролцоо эрүүл мэндийн болон бусад үйлчилгээний цэгийг ажиллуулах санал санаачилгыг хувийн хэвшлийнхний дунд өрнүүлэх;
- Худалдааны төв, эмнэлэг, засаг захиргаа, нийгмийн халамж, даатгалын байгууллага, банк зэрэг үйлчилгээний газрууд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ээлтэй байдлаар дотоод тохижилтоо хийх, ялангуяа, гадаах талбай, үүд хаалга, шат, ариун цэврийн өрөө зэрэг тусгай тоноглол, зориулалтын төхөөрөмж тавих стандартыг мөрдүүлэх, эдгээр байгууллагад ахмад настанд эхний ээлжинд үйлчлэх буюу тэдэнд зориулсан тусгай үйлчилгээг бий болгох;
- Нийтийн тээврийн хэрэгсэл дотор ахмад настанд зориулсан тоноглол бүхий суудал тавих, зогсоолын тавцан, замын гарц, байшингийн довжоо зэргийг ахмад настан болон

- тэргэнцэртэй иргэдэд саад болохгүйгээр засах, энэ талаарх холбогдох стандартыг заавал мөрдүүлж хэвшүүлэхэд чиглэсэн ухуулга нөлөөллийн ажлыг өргөжүүлэх;
- Гар утас, компьютер болон цахилгаан бараа, техникийн худалдаа эрхлэгчид өөрийн бараа бүтээгдэхүүнийг худалдан авч буй ахмад настнуудад зориулсан хялбар тайлбар, танилцуулгыг бэлтгэх, худалдан авсан бүтээгдэхүүнээ ашиглаж сурхад нь туслах зэрэг үйлчилгээний соёлыг хэвшүүлэх

## ДӨРӨВ. СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

### Зорилт 1. Насжилтын асуудлаарх үндэсний стратегийг хөгжлийн бодлого төлөвлөлтөд тусган хэрэгжүүлэх тогтолцоог бэхжүүлнэ.

#### Өнөөгийн байдал

Хүн амын хөгжил, насжилт зэрэг нь салбар дундын оролцоо зохицуулалт шаардах эдийн засгийн бүх салбарын үйл ажиллагаанд хамаарах өргөн хүрээтэй асуудал юм. Манай улсын хувьд хүн амын бүтцийн тааламжтай үед хөдөлмөрийн нөөцөө бүрэн ашиглаж, эдийн засгийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах замаар эдийн засгийн өсөлтийг хангах, түүний үр шимийг хүртэх боломжийг бүрдүүлэх, энэ үндсэн дээр хүн амын насжилтын үед тулгарах асуудлуудад урьдчилан бэлтгэхэд нэгдсэн удирдлага, зохион байгуулалт нэн чухал байна.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулиар Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хүн ам зүй болон хүүхэд, залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, гэр бүлийн хөгжлийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх, хүн амын хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал багтаж байна.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам өөрийн чиг үүрэгтээ багтаж буй эдгээр асуудлыг бусад салбарын бодлого, үйл ажиллагаатай уялдуулан зохицуулах ажлыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдаар ахлуулсан Хүн амын хөгжлийн асуудлаарх орон тооны бус Үндэсний хороогоор дамжуулан хэрэгжүүлж байна. Үндэсний хороо нь өөрийн эрх мэдлийн хүрээнд энэ чиглэлээр тодорхой арга хэмжээг авч байгаа хэдий ч эдийн засаг, нийгмийн хөгжлийн харилцан уялдаа холбоо, тэнцвэрт байдлыг хангахад зарим талаар учир дутагдалтай байна.

Түүнчлэн хүн амын насны бүтцийн өөрчлөлт, насжилтын төлөв байдлыг тооцоолох, түүний үр дүнг төлөвлөлтөд тусган хэрэгжүүлэх ур чадварыг төрийн бүх шатны байгууллагад ажиллагчдад эзэмшүүлэх, стратегийн хэрэгжилтийн явц, үр дүнг хянах, хяналт-шинжилгээ үнэлгээний тогтолцоог бүрдүүлэх болон түүнд шаардлагатай мэдээлэл, судалгааг сайжруулах явдал чухал болж байна.

#### Шийдвэрлэх асуудал

Хүн амын насны бүтцийн өөрчлөлт нь нийгмийн төдийгүй эдийн засгийн үр дагавартай асуудал учир хүн ам зүйн цонхны үе, ирээдүйн насжилтын асуудлыг хөгжлийн урт болон дунд хугацааны төлөвлөлтөд тусган, салбарын бодлого үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, түүнийг хэрэгжүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах институцийг бий болгох шаардлагатай байна. Түүнчлэн энэ асуудлаар хувийн хэвшил, иргэний нийгмийн санал санаачилгыг өрнүүлж, оролцоог нэмэгдүүлэх, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх явдал чухал байна.

Бүх шатанд ажиллагчдын хүн амын насны бүтцийн өөрчлөлт, хандлага, насжилтад сууриссан төлөвлөлт хийх чадавхийг бэхжүүлэх, тоо мэдээлэл, судалгааны олдоц, хүртээмжийг сайжруулах нь уг стратегийн хэрэгжилтэд онцгой ач холбогдолтой юм.

## **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

1. Стратегийг хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлнэ:

- Хүн амын хөгжлийн асуудлыг бүхэлд нь, ялангуяа, насжилтын асуудлыг эдийн засаг, нийгмийн бодлоготой уялдуулах чиг үүргийг хариуцуулахаар Хүн амын хөгжлийн асуудлаарх үндэсний хороог Ерөнхий сайдаар ахлуулан өөрчлөн зохион байгуулна. Хорооны дэд дарга нь Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, ажлын алба нь Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам байна.
- Хорооны бүрэлдэхүүнд төр, төрийн бус байгууллага, донор, хандивлагч, хувийн хэвшил, хэвлэл мэдээлэл, эрдэмтэн судлаачид, ахмад настны зэрэг төлөөллийг оруулна:
- Хорооны дүрэм, ажлын төлөвлөгөөг Хорооны хурлаар батална.
- Хороо нь гол үүрэгтэй оролцох байгууллагуудын тогтолцоог бүрдүүлж, тэдгээрийн чиг үүргийг нарийвчлан тодорхойлно. Иргэний нийгмийн оролцоо, санаачилгыг өрнүүлж, түүнийг хөхиүлэн дэмжинэ. Энэ хүрээнд стратегид туссан асуудлыг холбогдох салбар, байгууллагын бодлого, төлөвлөлтэд тусгах, салбар дундын зохицуулалт хийх, хэрэгжилтэд хяналт тавих, удирдамжаар хангах, зөвлөмж гаргах, хөрөнгө нөөцийг дайчлах чиглэлээр явуулах үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
- Хороо нь жил бүрийн Нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсвийн төслийг боловсруулахын өмнө хүн амын насжилт, ахмад настны аж байдлыг сайжруулах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, тулгамдсан асуудлыг тодорхойлох, түүнийг хэлэлцэх ажлыг зохион байгуулна.
- Хороо нь стратегийг хэрэгжүүлэх талаар гарч буй ахиц дэвшлийг урамшуулах, түгээн дэлгэрүүлэх, нэр хүндийг нь өсгөх, хувийн хэвшлийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх асуудлыг онцгой анхаарч ажиллана.

2. Стратегийг хэрэгжүүлэхэд төр, иргэний нийгмийн түншлэлийг бэхжүүлнэ.

- Стратегийг хэрэгжүүлэхэд яам, агентлагууд дараах үүрэгтэй оролцоно:
  - Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо нь Монгол Улсын үндэсний хөгжлийн дунд болон урт хугацааны бодлогод тусгах, бусад салбарын бодлого төлөвлөлтэд тусгуулах талаар удирдамж чиглэлээр хангана.
  - Сангийн яам стратегид туссан асуудлыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг тухайн жилийн төсөвт тусгах, ахмад настанд ээлтэй орчин бүрдүүлэх, дэд бүтцийг сайжруулахад шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар барих барилга, байгууламжийн төсвийн бодлогод тусгахад дэмжлэг үзүүлнэ.
  - Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам ахмад настан чадвар, чадамждаа тохирсон ажлыг тааваараа эрхлэх боломжийг бүрдүүлэх, нийгмийн баталгааг хангах чиглэлээр хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, холбогдох хөтөлбөр, дүрэм журмыг боловсруулан хэрэгжилтийг хангах, хүн амын тогтвортой өсөлтийг дэмжих ажлыг хариуцна.
  - Эрүүл мэндийн яам хүн ам эрүүл насжих, өвчин эмгэг, аваар ослоос урьдчилан сэргийлэх зан үйлийн төлөвшүүлэх, ахмад настанд зориулсан эрүүл мэндийн ээлтэй үйлчилгээг хөгжүүлэх, үйлчилгээ үзүүлэгчдийн чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
  - Зам тээвэр, барилга хот байгуулалтын яам ахмад настанд ээлтэй зам, тээвэр, дэд бүтцийг бий болгох ажлыг хариуцан зохион байгуулж, түүний стандартыг батлан мөрдүүлнэ.
- Бүх шатны төрийн захиргааны байгууллага стратегид туссан асуудлыг өөрийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөлтэд тусган хэрэгжүүлэх, бусад байгууллагатай хамтран ажиллах, хөрөнгө нөөцийг дайчлах ажлыг зохион байгуулна.
- Иргэний нийгэм, ялангуяа, төрийн бус байгууллагын оролцоог ахмад настан, тэдний гэр бүлтэй ажиллах, нийгэмд зөв хандлага төлөвшүүлэхэд чиглэсэн ажил үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх хэлбэрээр хангана.

- Аж ахуйн нэгж, байгууллага, хувийн хэвшил ахмад настанд ээлтэй орчин бүрдүүлэх талаар стратегид тусгагдсан асуудлыг байгууллагынхаа түвшинд хэрэгжүүлэх, ахмад настанд зориулсан төрөл бүрийн үйлчилгээг нээн ажиллуулах, тэдний мэдлэг, туршлагыг ашиглах, шийдвэр гаргахад зохиистой хэлбэрээр оролцуулах, зарим тулгамдсан асуудлыг шийдвэрлэх талаар манлайлах, төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулж буй зарим арга хэмжээг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажиллана.
- Хэвлэл мэдээллийн байгууллага насжилтад бэлтгэх, олон нийтэд зөв ойлголт, хандлага төлөвшүүлэх, ахмад настны хөгжилд оруулж буй хувь нэмэр, онцлог, өвөрмөц хэрэгцээ шаардлагын талаар хүн амын зан үйлийг өөрчлөхөд чиглэсэн нийтлэлийн бодлогыг хэрэгжүүлэх, ахмад настанд зориулсан өдөр тутмын хэрэгцээт мэдээллийг хүргэх нэвтрүүлэг, мэдээлэл, сурталчилгааг тогтмолжуулах чиглэлээр ажиллана.
- Судалгаа, шинжилгээний байгууллагууд ахмад настан, насжилтын асуудлаар судалгаа хийх, тоо мэдээллийн хүртээмж, чанар, ашиглалтыг сайжруулах, эрдэм шинжилгээний бүтээл туурвих зэрэг чиглэлээр хамтран ажиллана.

3. Стратегийг хэрэгжүүлэгчдийн ойлголт, хандлагыг сайжруулж, чадавхийг бэхжүүлнэ:

- Насжилтад бэлтгэх, ахмад настны онцлог хэрэгцээ, чадавх боломжийн асуудлаар шийдвэр гаргагчид, бодлого боловсруулагчдад зориулсан сургалт, семинар, ярилцлагыг тогтмолжуулна.
- Насжилт, ахмад настны асуудлаар хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр боловсруулахад ашиглах гарын авлага материалыг боловсруулан гаргана.
- Насжилтын талаарх мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, түгээх, үр дүнг нь үйл ажиллагаандаа ашиглах, бодлого, хөтөлбөрт тусгах чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааг тогтмолжуулна.
- Насжилтын асуудлаарх ойлголтыг сайжруулах, бусад

улс орнуудтай харилцан туршлага солилцох зорилгоор өөрийн оронд бус нутгийн болон олон улсын хурал, семинар, сургалтыг зохион байгуулах, бусад улс оронд зохион байгуулгаждаж байгаа ийм төрлийн үйл ажиллагаанд оролцоог өргөжүүлнэ.

- Нийгмийн ажилтан, үйлчилгээ үзүүлэгчид болон асран хамгаалагчдад насжилтын талаар ээрэг ойлголт, хандлага төлөвшүүлэх, ахмад настантай ажиллах ур чадварыг эзэмшүүлэх болон сайжруулах дэс дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.
- Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад ажиллагчид болон нийгмийн ажилтнуудад геронтолог, гериатрийн /хөгшрөл судал/ талаарх мэдлэг, ойлголт олгох шаталсан сургалтыг тасралтгүй зохион байгуулна.

4. Насжилт, ахмад настны талаарх мэдээлэл, судалгааг сайжруулж, стратегийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулна:

- Стратегийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг боловсруулан, ашиглана.
- Шалгуур үзүүлэлтүүдийг тооцох мэдээллийн эх сурвалжуудыг тодорхойлох, ахмад настны талаарх мэдээллийг нас, хүйс, байршил, бусад нийгэм, эдийн засгийн байдлаар ангилсан мэдээллийн санг үндэсний болон аймаг, дүүрэг, сумын түвшинд байгуулна.
- Үндэсний стратегийн хэрэгжилтийн тайлан, хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг үндэсний хорооны болон хэрэгжүүлэгч байгууллагуудын жил бүрийн зөвлөлдөх уулзалтанд танилцуулна.
- Стратегийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээг 2 жил тутам, үнэлгээг 3-4 жил тутам хийнэ. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнд үндэслэн шаардлагатай бол стратегид нэмэлт өөрчлөлт оруулж болно.
- Хүн амын насны бүтцийн өөрчлөлт, насжилтын эдийн засаг, нийгмийн нөлөөлөл, тооцоолол, загварыг боловсруулах, сэдэвчилсэн судалгаа хийх ажлыг өргөжүүлнэ.
- Насжилт, ахмад настанд ээлтэй орчинг бүрдүүлэх, шинэ техник технологийг нээх, нэвтрүүлэхэд чиглэсэн эрдэм шинжилгээний ажлыг өргөжүүлнэ.

## ТАВ. СТРАТЕГИЙН САНХҮҮЖИЛТ

Стратегийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

- Насжилтыг угтах болон Ахмад настны аж байдлыг сайжруулах стратегид туссан зорилт, үйл ажиллагааг холбогдох салбарын бодлого, төлөвлөлттэй уялдуулан улс, орон нутгийн төсөвт тусгана.
- Стратегийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах, чадавх бэхжүүлэх, мэдээлэл, судалгаа, сургалт, сурталчилгааг өргөжүүлэх, иргэний нийгэм, олон нийтийг идэвхжүүлэх зэрэг арга хэмжээнд шаардлагатай хөрөнгийг олон улсын байгууллага, хандивлагчидтай хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх замаар бүрдүүлнэ.

## ХАВСРАЛТ ХҮСНЭГТҮҮД

Хавсралт 1

### МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ХЭТИЙН ТООЦОО

| Насны<br>бүлэг | 2000           |                |                | 2005           |                |                |
|----------------|----------------|----------------|----------------|----------------|----------------|----------------|
|                | Эрэгтэй        | Эмэгтэй        | Бүгд           | Эрэгтэй        | Эмэгтэй        | Бүгд           |
| 0-4            | 125330         | 122369         | 247699         | 128278         | 125114         | 253392         |
| 5-9            | 145298         | 142312         | 287610         | 123721         | 121207         | 244927         |
| 10-14          | 160379         | 159217         | 319596         | 144541         | 141757         | 286298         |
| 15-19          | 134235         | 130917         | 265152         | 158869         | 158159         | 317028         |
| 20-24          | 118827         | 118530         | 237357         | 130181         | 128202         | 258383         |
| 25-29          | 108697         | 109430         | 218127         | 113790         | 115073         | 228863         |
| 30-34          | 93103          | 96049          | 189152         | 105027         | 106769         | 211796         |
| 35-39          | 85424          | 88358          | 173782         | 91653          | 94813          | 186465         |
| 40-44          | 63046          | 65041          | 128087         | 83669          | 86912          | 170580         |
| 45-49          | 40838          | 42614          | 83452          | 61194          | 63602          | 124797         |
| 50-54          | 27896          | 30333          | 58229          | 39055          | 41269          | 80324          |
| 55-59          | 27566          | 28710          | 56276          | 26062          | 28941          | 55003          |
| 60-64          | 20920          | 21661          | 42581          | 24840          | 26728          | 51568          |
| 65-69          | 16091          | 19565          | 35656          | 17839          | 19323          | 37162          |
| 70-74          | 8826           | 11551          | 20377          | 12588          | 16215          | 28803          |
| 75+            | 9530           | 16998          | 26528          | 10227          | 16645          | 26871          |
| <b>Бүгд</b>    | <b>1186006</b> | <b>1203655</b> | <b>2389661</b> | <b>1271534</b> | <b>1290729</b> | <b>2562260</b> |

| Насны<br>бүлэг | 2008           |                |                | 2010           |                |                |
|----------------|----------------|----------------|----------------|----------------|----------------|----------------|
|                | Нийт           | Эрэгтэй        | Эмэгтэй        | Нийт           | Эрэгтэй        | Эмэгтэй        |
| 0-4            | 141260         | 138497         | 279757         | 143437         | 140367         | 283804         |
| 5-9            | 124752         | 121916         | 246667         | 131436         | 128822         | 260259         |
| 10-14          | 126217         | 123445         | 249662         | 122445         | 119780         | 242226         |
| 15-19          | 148000         | 145727         | 293727         | 138346         | 135569         | 273915         |
| 20-24          | 153953         | 153121         | 307073         | 156634         | 156063         | 312697         |
| 25-29          | 123859         | 121665         | 245524         | 133269         | 131132         | 264400         |
| 30-34          | 109483         | 110252         | 219735         | 112697         | 112700         | 225398         |
| 35-39          | 98900          | 100820         | 199719         | 102670         | 104131         | 206801         |
| 40-44          | 85130          | 89419          | 174549         | 88079          | 92007          | 180086         |
| 45-49          | 75925          | 80091          | 156015         | 80212          | 84962          | 165175         |
| 50-54          | 52796          | 55887          | 108683         | 60929          | 64731          | 125660         |
| 55-59          | 32623          | 35599          | 68222          | 38544          | 41742          | 80286          |
| 60-64          | 22345          | 25789          | 48134          | 23607          | 27318          | 50925          |
| 65-69          | 19900          | 22711          | 42610          | 19720          | 23192          | 42913          |
| 70-74          | 12611          | 15421          | 28033          | 13911          | 17076          | 30987          |
| 75+            | 11206          | 20626          | 31832          | 11642          | 21110          | 32752          |
| <b>Нийт</b>    | <b>1338960</b> | <b>1360986</b> | <b>2699942</b> | <b>1377578</b> | <b>1400702</b> | <b>2778284</b> |

**Хавсралт 2**

**ХҮН АМЫН НАСНЫ БҮТЭЦ, ХҮН АМ ЗҮЙН АЧААЛАЛ**

| Нас                 | 2008 | 2009 | 2010 | 2015 | 2020 | 2025 | 2030 |
|---------------------|------|------|------|------|------|------|------|
| 0-4                 | 10.4 | 10.2 | 10.2 | 9.7  | 8.7  | 7.7  | 7.4  |
| 5-9                 | 9.1  | 9.4  | 9.4  | 9.5  | 9.1  | 8.3  | 7.3  |
| 10-14               | 9.2  | 8.9  | 8.7  | 8.8  | 8.9  | 8.6  | 7.9  |
| 0-14                | 28.7 | 28.5 | 28.3 | 28.0 | 26.7 | 24.6 | 22.6 |
| 15-19               | 10.9 | 10.4 | 9.9  | 8.1  | 9.6  | 8.1  | 8.2  |
| 20-24               | 11.4 | 11.4 | 11.3 | 9.1  | 8.0  | 8.9  | 8.1  |
| 25-29               | 9.1  | 9.3  | 9.5  | 10.3 | 6.8  | 7.6  | 7.4  |
| 30-34               | 8.1  | 8.1  | 8.1  | 8.7  | 9.5  | 8.0  | 6.9  |
| 35-39               | 7.4  | 7.4  | 7.4  | 7.4  | 8.2  | 8.8  | 7.7  |
| 15-39               | 46.9 | 46.6 | 46.2 | 43.6 | 42.1 | 41.4 | 38.3 |
| 40-44               | 6.5  | 6.5  | 6.5  | 6.8  | 6.8  | 7.6  | 8.5  |
| 45-49               | 5.8  | 5.9  | 5.9  | 5.9  | 6.2  | 6.4  | 7.2  |
| 50-54               | 4.0  | 4.3  | 4.5  | 5.3  | 5.4  | 5.7  | 6.0  |
| 55-59               | 2.5  | 2.7  | 2.9  | 4.0  | 4.8  | 4.9  | 5.3  |
| 60-64               | 1.8  | 1.8  | 1.8  | 2.5  | 3.5  | 4.2  | 4.5  |
| 40-64               | 20.6 | 21.2 | 21.6 | 24.5 | 26.7 | 28.8 | 31.5 |
| 65-69               | 1.6  | 1.6  | 1.5  | 1.5  | 2.1  | 3.0  | 3.6  |
| 70-74               | 1.0  | 1.0  | 1.1  | 1.1  | 1.2  | 1.7  | 2.4  |
| 75+                 | 1.2  | 1.2  | 1.2  | 1.3  | 1.4  | 1.5  | 2.0  |
| 65+                 | 3.8  | 3.8  | 3.8  | 3.9  | 4.7  | 6.2  | 8.0  |
| Хүн ам зүйн ачаалал | 48.1 | 47.6 | 47.3 | 46.8 | 45.6 | 43.9 | 43.8 |
| Хүүхэд              | 42.5 | 42.0 | 41.7 | 41.1 | 38.8 | 35.0 | 32.4 |
| Ахмад настан        | 5.6  | 5.6  | 5.6  | 5.7  | 6.8  | 8.8  | 11.5 |

Эх үүсвэр: Монгол Улсын хүн амын 2008-2030 оны хэтийн тооцоо, Улаанбаатар 2008 он

|       | 2015    |         |         | 2020    |         |         |
|-------|---------|---------|---------|---------|---------|---------|
|       | Нийт    | Эрэгтэй | Эмэгтэй | Нийт    | Эрэгтэй | Эмэгтэй |
| 0-4   | 145593  | 142461  | 288055  | 138165  | 135178  | 273343  |
| 5-9   | 142470  | 139523  | 281993  | 144988  | 141912  | 286900  |
| 10-14 | 131567  | 129010  | 260577  | 142194  | 139346  | 281540  |
| 15-19 | 121976  | 119460  | 241436  | 131187  | 128766  | 259953  |
| 20-24 | 136718  | 134275  | 270992  | 121012  | 118741  | 239753  |
| 25-29 | 153325  | 153282  | 306607  | 134748  | 132664  | 267412  |
| 30-34 | 129796  | 127972  | 257769  | 150842  | 151144  | 301986  |
| 35-39 | 109628  | 110205  | 219833  | 127535  | 126129  | 253664  |
| 40-44 | 99672   | 101898  | 201570  | 107293  | 108532  | 215825  |
| 45-49 | 85104   | 89790   | 174893  | 96946   | 99912   | 196858  |
| 50-54 | 76608   | 82255   | 158864  | 81818   | 87383   | 169201  |
| 55-59 | 56954   | 61830   | 118785  | 72066   | 78949   | 151015  |
| 60-64 | 34709   | 38954   | 73663   | 51739   | 58081   | 109820  |
| 65-69 | 20195   | 24723   | 44918   | 29768   | 35309   | 65077   |
| 70-74 | 14193   | 18688   | 32881   | 15781   | 21168   | 36949   |
| 75+   | 14818   | 25239   | 40058   | 15952   | 28401   | 44353   |
| Нийт  | 1473326 | 1499565 | 2972894 | 1562034 | 1591615 | 3153649 |

|       | 2025    |         |         | 2030    |         |         |
|-------|---------|---------|---------|---------|---------|---------|
|       | Нийт    | Эрэгтэй | Эмэгтэй | Нийт    | Эрэгтэй | Эмэгтэй |
| 0-4   | 128674  | 125874  | 254548  | 129522  | 126694  | 256216  |
| 5-9   | 138833  | 135867  | 274700  | 128325  | 125556  | 253880  |
| 10-14 | 144789  | 141791  | 286580  | 138651  | 135754  | 274405  |
| 15-19 | 142061  | 139362  | 281423  | 144518  | 141639  | 286157  |
| 20-24 | 129740  | 127562  | 257303  | 141612  | 139110  | 280721  |
| 25-29 | 120875  | 118579  | 239454  | 129231  | 127248  | 256479  |
| 30-34 | 135591  | 134249  | 269840  | 120295  | 118189  | 238485  |
| 35-39 | 146964  | 146954  | 293918  | 134652  | 133595  | 268247  |
| 40-44 | 126832  | 126465  | 253297  | 145358  | 145835  | 291193  |
| 45-49 | 105875  | 107463  | 213338  | 124588  | 124935  | 249523  |
| 50-54 | 92533   | 96589   | 189122  | 102789  | 105365  | 208154  |
| 55-59 | 78640   | 85461   | 164101  | 88110   | 93557   | 181667  |
| 60-64 | 65315   | 73856   | 139172  | 72537   | 81176   | 153713  |
| 65-69 | 44859   | 53107   | 97966   | 57177   | 67985   | 125162  |
| 70-74 | 24379   | 31403   | 55782   | 36127   | 46536   | 82663   |
| 75+   | 17403   | 32079   | 49483   | 24648   | 43170   | 67818   |
| Нийт  | 1643363 | 1676661 | 3320027 | 1718140 | 1756347 | 3474483 |

Эх үүсвэр: Хүн амын хэтийн тооцоо, 2000-2030 он, YCX

### ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

|  | Хэмжих нэгж | 2000   | 2001   | 2002   | 2003   | 2004   | 2005   | 2006   | 2007   | 2008   |
|--|-------------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|
| Хөдөлмөрийн насны хүн амын тоо   | МЯН.ХҮН     | 1347.4 | 1402.8 | 1439.2 | 1488.9 | 1531.1 | 1577.0 | 1619.6 | 1642.2 | 1688.7 |
| Ажиллах хүч  | МЯН.ХҮН     | 847,6  | 872,6  | 901,7  | 959,8  | 986,1  | 1001,2 | 1042,8 | 1054,0 | 1071,5 |
| Ажиллагчдын тоо*   | МЯН.ХҮН     | 809,0  | 832,3  | 870,8  | 926,5  | 950,5  | 968,3  | 1009,9 | 1024,1 | 1041,7 |
| Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо | МЯН.ХҮН     | 38,6   | 40,3   | 30,9   | 33,3   | 35,6   | 32,9   | 32,9   | 29,9   | 29,8   |
| Ажил эрхлэгэтийн хүн амын тоо  | МЯН.ХҮН     | 282,7  | 278,9  | 265,8  | 233,0  | 248,3  | 260,4  | 257,6  | 261,4  | 267,5  |
| Хөдөлмөрийн насны суралцагчдын тоо                                     | МЯН.ХҮН     | 153,7  | 175,1  | 196,5  | 214,3  | 218,0  | 237,0  | 243,3  | 255,5  | 270,5  |
| Хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадваргүй хүн амын тоо                   | МЯН.ХҮН     | 77,9   | 88,2   | 85,8   | 91,5   | 89,1   | 85,8   | 82,3   | 76,9   | 83,7   |
| Хөдөлмөр оролцооны түвшин  | хувь        | 62,9   | 62,2   | 62,7   | 64,5   | 64,4   | 63,5   | 64,4   | 64,2   | 63,5   |
| Ажил эрхлэлтийн түвшин   | хувь        | 60,0   | 59,3   | 60,5   | 62,2   | 62,1   | 61,4   | 62,4   | 62,4   | 61,7   |
| Ажилгүйдлийн түвшин  | хувь        | 4,6    | 4,6    | 3,4    | 3,5    | 3,6    | 3,3    | 3,2    | 2,8    | 2,8    |
| **   |             |        |        |        |        |        |        |        |        |        |

Тайлбар: \* Гадаадд гэрээгээр болон гадаад харилцааны яамны шугамаар жиллаж байгаа хүмүүс ороогүй.

\*\* Аймаг, найслеплийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдээр тооцсон.

Эх үүсвэр: Хүн амьн ажил эрхлэлтийн судалгай, 2008, УСХ

НҮБ-ын Хүн амын сангийн  
дэмжлэгтэйгээр хэвлүүлэв.